

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН  
Я.ШАРАВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар Б-18

Мөрөн

Ажлаас чөлөөлж, ажилд томилох, ажил  
хавсруулсан гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгох тухай

Монгол улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1, 26 дугаар зүйлийн 26.2, 27 дугаар зүйлийн 27.3, 28 дугаар зүйлийн 28.1.9, 28.1.14, 28.2.1 дэх заалтууд, “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114, ЦУОШГ-ын даргын 2017 оны А/56 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ЦАЗНЭ-ийн асуудал хариуцсан технологич инженер Г.Адъяасүрэнг 2017 оны 05 дугаар 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн өдрөөс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон, ХАБЭА/ЦАЗНЭ-ийн асуудал хариуцсан технологич инженерээр, жолооч Ц.Баттогтохыг цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн /ЦАЗНЭ/ зэвсгийн техникчээр хавсруулан ажиллуулахаар томилж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж ажиллуулсугай.

2. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч:

Г.Адъяасүрэн - ЦАЗНЭ-ийн болон ХАБЭА-н асуудал  
хариуцсан ажилтан

Гишүүдэд: Н.Эрдэнэцэцэг - ЗСААХ-ийн дарга, нягтлан бодогч  
Б.Өнөрбат - ЦУОТХ-н дарга, багаж хэмжил зүйн инженер  
С.Будрагчаа - Аэрологийн технологич инженер  
Д.Балжинням - Дэлгэрмөрөн-Мөрөн ус судлалын харуулын  
ажиглагч

3. Г.Адъяасүрэнгийн цалинг өмнө тогтооноор буюу төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээний ТҮ-8-5 шатлалаар 741000 /Долоон зуун дөчин нэгэн мянга/ төгрөгөөр, жолооч Ц.Баттогтоход цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны хугацаанд үндсэн цалингийн 40%-иар тооцож нэмэгдэл цалин олгохыг ня-бо Н.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Г.Адъяасүрэн, Ц.Баттогтох нарын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж гаргахыг ЦУОТХ-ийн дарга Б.Өнөрбатад үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан УЦУОША-ны даргын 2014 оны Б/18 дугаар тушаал, УЦУОШГ-ын даргын 2017 оны Б/01 тушаалын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.ҮНЭНБАЯР

Tushaal 2017 B-18